

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2026.05.04

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ


ТОВЧ

- ХНС-ийн ээлжит хурал болж хүүг хэвээр хадгаллаа.
- Powell 5-р сарын 15-нд ажлаа өгөөд ХНС-ийн Удирдах зөвлөлийн гишүүн хэвээр үлдэнэ гэдгээ мэдэгдлээ.
- S&P 500 индекст багтах компаниудын тайлан хүлээлтээс сайн гарч байна.
- Компаниудын CAPEX зардал өндрөөр төлөвлөгдөж байгаа нь AI эрэлт их байгааг илтгэж байна.
- Хятадын AI салбарт томоохон тэсрэлт болж байна.
- Хятадын цахилгаан автомашины өрсөлдөөн AI салбар луу чиглэж эхэллээ.
- Hua Hong, SMIC зэрэг компаниуд анхаарлын төвд хэвээр байна.



S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
Дундаж	7,645





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.04.27-05.03

ХНС-ийн ээлжилт хурал болж хүүг хэвээр нь хадгаллаа

ХНС бодлогын хүүг өөрчлөлгүй 3.5%–3.75%-д хэвээр үлдээхээр боллоо. Гэвч энэ удаагийн хурлын гол онцлог нь шийдвэр бус, харин дотоод “хуваагдал” байлаа. Санал хураалт 8-4 харьцаатай гарсан нь 1992 оноос хойших хамгийн их зөрүүтэй шийдвэр боллоо.

Jerome Powell мэдэгдэлдээ инфляц ойрын хугацаанд өсөх хүлээлттэй байгааг онцолж, ялангуяа эрчим хүчний үнэ нэмэгдсэн нь үнийн дарамтыг нэмэгдүүлж байгааг дурдсан. Мөн Пауэлл 5-р сарын 15-нд ажлаа өгөөд Холбооны Нөөцийн Сангийн Удирдах зөвлөлийн гишүүн (Governor) хэвээр үлдэнэ гэдгээ мэдэгдлээ.

ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫН ТАЙЛАН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГИЙГ ТОДОРХОЙЛОВ

АНУ-ын технологийн томоохон компаниудын улирлын тайлан зах зээлд хүчтэй нөлөө үзүүлсэн ба нэг зүйл тодорхой харагдлаа. Зөвхөн ашиг, орлогын өссөн үзүүлэлт хангалтгүй, харин ирээдүйн хөрөнгө оруулалтын зардал ба хүлээлт зах зээлийг хөдөлгөж байна.

Өнгөрсөн долоо хоногт “Magnificent 7”-ийн гол тоглогчид болох Alphabet, Microsoft, Amazon, Meta Platforms зэрэг компаниудын ихэнх нь хүлээлтээс давсан гүйцэтгэл үзүүлсэн ч хувьцааны ханшийн хөдөлгөөн зөрүүтэй байв.

ТЕХНОЛОГИЙН КОМПАНИУДЫН CAPEX ЗАРДЛЫГ АЖИГЛАХ НЬ ЧУХАЛ

Тайлангаас харагдсан хамгийн чухал зүйл нь хиймэл оюун ухааны эрэлт үргэлжилсэн хэвээр байгаа. Харин эрэлтийг хангаж чадах дэд бүтцийг хэн нь хурдан барих вэ? гэдэг гол асуудал болоод байгаа гэсэн дүгнэлтэнд хүрлээ. Мөн компаниудын CAPEX зардлын төлөвлөлт өндөр байгаа нь асар их эрэлтийг хангах хүчин чадал дутуу байгааг нотлон харуулж байна.

*CAPEX гэдэг нь үндсэн хөрөнгө оруулалтын зардал бөгөөд технологийн компаниуд дата төвүүдээ өргөжүүлж эрэлтийг хангахаар CAPEX аа өндрөөр төлөвлөөд байна.

CAPEX өндөр байвал компани:

- Өсөлтөд хөрөнгө оруулж байна
- Хүчин чадлаа нэмэгдүүлж байна
- Ирээдүйн орлогоо өсгөхөөр бэлдэж байна

Company	Estimates	Reported	Revenue Growth	EPS Surprise	2026 CapEx	After-hours stock price change
MSFT Microsoft Corp.	EPS: \$4.07 Revenue: \$81.40 Billion	EPS: \$4.27 Revenue: \$82.89 Billion	18.3%	4.9%	\$190 Billion ↑ (AI related)	Flat
AMZN Amazon.com, Inc.	EPS: \$1.60 Revenue: \$177.84 Billion	EPS: \$1.56 Revenue: \$181.52 Billion	16.6%	-2.5%	Expected to increase ↑ (AI related)	4%
META Meta Platforms, Inc.	EPS: \$6.71 Revenue: \$55.49 Billion	EPS: \$7.31 Revenue: \$56.31 Billion	33.1%	8.9%	\$125-\$145 Billion ↑ (AI investment cycle)	-6%
GOOGL Alphabet Inc.	EPS: \$2.64 Revenue: \$92.22 Billion	EPS: \$5.11 Revenue: \$109.90 Billion	21.8%	93.6%	\$190 Billion ↑ (AI data centers + cloud infrastructure)	7%
QCOM Qualcomm Incorporated	EPS: \$2.56 Revenue: \$10.62 Billion	EPS: \$2.65 Revenue: \$10.60 Billion	-3.5%	3.5%	Expected to increase gradually (AI data center entry)	13%



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.04.27–05.03

ТЕХНОЛОГИЙН ӨРСӨЛДӨӨНД ХЯТАД УЛС ДАХИН ШИНЭ АЛХАМЫГ ХИЙЛЭЭ

Хятад улс Meta компанийн хиймэл оюуны стартап Manus-ийг 2 тэрбум ам.доллараар худалдан авах хэлцлийг албан ёсоор зогсоолоо. Энэ нь зүгээр нэг компанийн наймаа цуцлагдсан асуудал биш, харин Хятад болон АНУ-ын хиймэл оюуны өрсөлдөөн шинэ шатанд орсныг харуулсан том дохио боллоо.

Өөрөөр хэлбэл Хятад улс одоо зөвхөн чип, программ хангамж бус, авьяаслаг инженерүүд, өгөгдөл, технологийн мэдлэгээ гадагш алдахгүй байх бодлогод илүү төвлөрч эхэлжээ. Хятадад эхэлсэн AI компаниудыг гадаад руу шилжүүлээд Америкийн том компанид зарах замыг хааж эхэлж байна гэсэн үг.

ХЯТАДЫН ЦАХИЛГААН АВТОМАШИНЫ ДАЙН AI ТЕХНОЛОГИЙН ӨРСӨЛДӨӨН БОЛЛОО

Хятадын цахилгаан автомашины зах зээлд өмнө нь үйлдвэрлэгчид үнээ бууруулж өрсөлддөг байсан бол одоо өрсөлдөөний төв нь AI технологи, ухаалаг салон, дотоод программ хангамж руу шилжиж байна. Өөрөөр хэлбэл хямд үнэ биш, илүү ухаалаг машин хэн хийх вэ гэдэг шинэ үе эхэлжээ.

Өмнө нь компаниуд батарейн зай, цэнэглэх хугацаа, жолоодлогын туслах системээр өрсөлдөж байсан бол одоо машин доторх хиймэл оюун ухаан хамгийн чухал ялгарал болж байна. Alibaba-ийн Qwen AI автомашинуудад хүчтэй нэвтэрч байгаа. Мөн Hua Hong Semiconductor-н 7 nm хүчин чадатай чип автомашины технологит хүчтэй нэвтрэн орж ирж байна.

HKEX:981 SMIC



HKEX:1347 Hua Hong



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

© 2026 Earnings Whispers

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open

© 2026 Earnings Whispers